



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2019 оны 05 сарын 30 өдөр

Дугаар A/40

Улаанбаатар хот

Арилжаанд оролцох эрхийг сэргээх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, "Монголын хөрөнгийн бирж" төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.11, Гишүүнчлэлийн журмын 5 дугаар зүйлийн 5.3.1 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Гүйцэтгэх захирлын 2019 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн А/36 дугаар тушаалаар арилжаанд оролцох эрх нь хязгаарлагдсан "Евразия Капитал Холдинг ҮЦК" ХК-ийн арилжаанд оролцох эрхийг 2019 оны 5 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн сэргээсүгэй.
2. Цаашид хууль тогтоомж, журам заавар болон "Монголын хөрөнгийн бирж" төрийн өмчит хувьцаат компанийтай байгуулсан "Гишүүнчлэлийн гэрээ"-гээр хүлээсэн үүргээ тогтмол биелүүлэн ажиллахыг "Евразия Капитал Холдинг ҮЦК" ХК /Г.Оюунболд/-д анхааруулсугай.
3. Үнэт цаасны арилжааны програмд нэвтрэх эрх сэргээхийг Үйл ажиллагааны газрын Арилжааны алба /Д.Алдармаа/-нд, тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, зохицуулалтын газрын Хяналт шинжилгээний алба /Д.Баттулга/-нд тус тус үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Х.АЛТАЙ



000193